

**“ЖИНХУА ОРД” ХХК-НИЙ ХЭНГИЙ АЙМГИЙН ДАРХАН
СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-006701 ТООТ АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙД “ДӨРВӨЛЖИНГИЙН
ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-006701/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5002486/**

Улаанбаатар хот

2025 он

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

1. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	9
4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ.....	12
5. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛТ	18
6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ	21
7. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	22
8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	27
9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	36
10. ТЭРБУМ МОДНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ.....	39
11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БОЛОН БУСАД ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУДЫН БАРИМТ	40
12. НЭГДСЭН ДҮГНЭЛТ	43
13. ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД.....	44

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оын А/134 дүгээр тушаалын зөвшөөрлөөр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 9-р сарын 19-ны өдрийн А/527 дугаар тушаалаар батлав.

УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЛМААС ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН МЭДЭЭ

1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХАЯГИЙН ХЭСЭГ

Регистрийн дугаар	5	0	0	2	4	8	6
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	“Жинхуа Орд” ХХК						
Байршил	Нэр		Код				
Аймаг, нийслэл	Хэнтий						
Сум, дүүрэг	Дархан						

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тусгай зөвшөөрлийн дугаар	М	V	0	0	6	7	0	1
Тусгай зөвшөөрлийн талбай, га	59							
Ашиглалт эхэлсэн он, сар, өдөр	2	0	0	7	0	5	1	1
Ашигт малтмалын төрөл	Дөрвөлжингийн төмрийн ордыг ашиглах							
Ашиглалтын төрөл	Ил уурхай							

3. УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТ

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Тайлант онд (ашиглалт хийсэн)
А	Б	В	1	2
Олборлолтод өртсөн нийт талбай	1	-	Х	Х
Нийт талбай	2		59	
Ашигласан талбай, га	3		6	2025
Хаягдал чулуулгийн овоолго	4	га	3	
	5			
Хөрсний овоолго	6	мян.м ³	415.05	Бэлчээрийн зориулалт
	7			
Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар	8	Га	4.1	Барилга байгууламж
Бусад	9	Га	6.2	Илүү ашиглалт

4. УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Техникийн	Биологийн
А	Б	В	1	2	3
Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан нөхөн сэргээлт хийх нийт талбайн хэмжээ	10	га		1 га	
	11	мян.м ³		-	х
Тайлант онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбай	12	Га		1 га	
	13	мян.м ³		40000	х
Нөхөн сэргээлт нийт хийсэн талбай, мөр14 ≥ мөр16, мөр15 ≥ мөр17	14	Га			
	15	мян.м ³			х
Тайлант онд нөхөн сэргээлт хийсэн талбай	16	Га			
	17	мян.м ³			х
Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан нийт зардал, мөр18 ≥ мөр19	18	мян.төг			
Тайлант онд нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан зардал	19	мян.төг	12.000.000	12.000.000	
Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны нийт хөрөнгө, мөр20 ≥ мөр21	20	мян.төг	37.805.000	х	х
Тайлант онд байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгө	21	мян.төг	37.805.000	х	х
Байгаль хамгаалахад зарцуулсан нийт зардал, мөр22 ≥ мөр23	22	мян.төг	37.805.000	х	х
Тайлант онд байгаль хамгаалахад зарцуулсан зардал	23	мян.төг	37.805.000	х	х

Тайлбар:

Тус уурхай өмнөх 2024 онд мөн багахан хугацаанд ажилласан бөгөөд засвар, зогсолтын хугацаа нилээд байсан болно. Бид энэхүү тайлангийн хүлээнд 2025 онд байгаль орчны хамгаалах үйл ажиллагааны хийсэн зүйлүүдээ тайлагнаж байгаа болно.

1. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Жинхуа орд” ХК-ний Ашигт малтмал ашиглалтын MV-006701 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий Дөрвөлжингийн төмрийн хүдрийн орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 320 км, Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрээс баруун тийш 13км, төмөр замын Айраг өртөөнөөс зүүн хойш 75 км -т Хэнтий аймгийн Дархан сумын нутаг Хөх овоотын толгодод байрлана.

Уул зүй:

Тус газар нутгийн ойролцоох хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1313.6 м-т өргөгдсөн, хайгуулын талбайгаас баруун урд зүгт 7 км зайтай орших Хар Дөрвөлж уул юм. Мөн түүнээс гадна сумын нутагт далайн түвшнээс дээш 1878 м өргөгдсөн Чойрын Богд уул, Их Хонгор уул, Бага хонгор уул, Баянцогт уул, Өлгий уул, Идэр майхан уул, Их нартын хад, Халзан уулын болон Далан түрүүний рашаан амралт хайгуулын талбайгаас зүүн урагш 4 км зайд, Бургасны ам, Буйлсны ам, Хуурайн ам, Улаан хадны булаг, Сэнжит хад, Арслан хад, Ембүү хад зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудаар элбэг.

Энэ нутаг нь газар зүйн бүсийн ангиллаар хээр тал, говийн бүсэд хамрагдана. Тус нутагт өндөр уул нуруу, гол мөрөн байхгүй. Газрын гадаргуу нь жижиг гүвээ, толгод, тэгшивтэр тал гадаргаас бүрдэнэ. Толгодын харьцангуй өндөр 40-70 м-т хэлбэлзэнэ.


Судалгааны талбайд ой мод, намаг шавар байхгүй.

Шорвог устай жижиг нуурууд, түүний хуурай ай савууд, хужирлаг цайдам, хөндий бүхий хотгоруудын хаяа, хязгаар нь алсуур налуу, сулхан хэрчигдэлтэй оршдог. Чулуулгийн үндсэн илэрц нь толгодын орой хэсэг мөн бага хэмжээгээр толгодын хажуу тал, хаяа, хөндий, хуурай сайруудын ёроолд тус тус тохиолддог.

Ус зүй:

Судалгааны талбай нь жилийн дөрвөн улирал ээлжлэн солигддог эх газрын эрс тэс уур амьсгалтай. Судалгааны талбайн хэмжээнд тогтмол урсгал ус байхгүй. Зуны улирлын сүүлч, намраар үргэлжилсэн ширүүн борооны дараа хөндий, хуурай сайруудаар хэмхдэс чулуулаг зөөвөрлөсөн түр зуурын булингартай үерийн ус урсдаг. Нутаг дэвсгэрийн хүрээнд худаг, шанд харьцангуйгаар элбэг. Худгийн усны нөөц тогтоогдоогүй, ундарга нь 0.2-0.8 л/сек.

Үүнээс гадна хүн, малын ундаанд удаан хугацаагаар хэрэглээгүй дарагдсан буюу усгүй худаг, шандууд ч нэлээд тааралдана. Гэвч эдгээрийн ихэнх нь эрдэсжилт ихтэй тул ундны болон техникийн хэрэгцээнд ашиглахад тохиромжгүй юм. Хайгуулын анги зүүн урагш 4,5 км зайтай орших Далан түрүүний рашаанаас ус авч байв.



Зураг.1. Төслийн 1:35.000 масштабтай зураглалын ерөнхий харагдах байдал

Хүснэгт 1. Төслийн талбайн солбилцол

№	Е	Н
1	109°18'51.71"	46°12'41.65"
2	109°18'21.72"	46°12'41.65"
3	109°18'21.72"	46°13'11.65"
4	109°18'51.71"	46°13'11.65"

Газар ашиглалтын байдал

Ашигт Малтмалын Газраас “Жинхуа орд” ХХК-нд АМГ-ын даргын 2007 оны 05 сарын 11-ны өдрийн шийдвэрээр Хэнтий аймгийн Дархан сумын Дөрвөлжин нэртэй газарт орших 59 гектар талбайд Дөрвөлжингийн төмрийн хүдрийн ордод ашигт малтмал ашиглалтын MV-006701 тоот тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгосон байна.



Зураг.2. Ажилчдын байр



Зураг.3. Баяжуулах үйлдвэр



Зураг.4. Төслийн газар ашиглалтын байдал

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Уур амьсгалын нөхцөл, үнэлгээ

Хэнтий аймгийн Дархан сумын нутаг дах Баргилтын төмрийн хүдрийн орд газар орчим нь Хэнтий аймгийн баруун өмнөд хязгаарт, Хэрлэн голын өмнөд биед, хойд өргөрөгийн 46.19⁰, зүүн уртрагийн 109.16⁰ –ийн солбицолд, далайн түвшнээс 1475-1520.0 м өндөрт оршино.

Бор Өндөрт 1986 онд цаг уурын ажиглалтын харуул байгуулсан боловч нэг талаар ажиглалтын тасалдал ихтэй, нөгөө талаар хоногт Улаанбаатарын цагаар 08,14, 20 цагт буюу зөвхөн өдрийн гэрэлтэй цагт хэмжилт хийдэг учраас уур амьсгалын хэмжигдэхүүний бодит утга гаргаж авахад хүрэлцээ муутай учир энэхүү тодорхойлолтыг хөрш зэргэлдээ орших Дархан, Иххэт сумуудын цаг уурын өртөөний мэдээллийг ашиглан гаргаж авсан болно.

Төсөл хэрэгжих орчны жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа урт /жилийн 178 хоногт агаарын хоногийн дундаж температур 0.0⁰С-аас бага/, агаарын температурын жилийн болон хоногийн хэлбэлзлэл ихтэй, хур тунадас бага, үүшил, агаарын чийгшил багатай, эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг.

Дулаан хүйтний горим

Жилийн дундаж агаарын температур нь “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт. БНБД. 2.01.01-93”-д өгснөөр 0.7⁰С орчим буюу ойролцоо орших Чойрын олон жилийн дунджаас 0.4⁰С орчмоор дулаан байна. Гэхдээ уур амьсгалын дулааралтын улмаас ерээд оноос хойшхи мэдээг оруулан авч үзвэл энэхүү уур амьсгалын нормоос ихээхэн дулаарч байгаа байдал харагдана. Тухайлбал 2002-2006 оны дунджаар жилийн дундаж агаарын температур 2.0⁰С болж дулаарсан байна.

Энэ бол барилга байгууламжийн зураг төслийн ажилд одоо мөрдөж байгаа “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт. БНБД. 2.01.01-93”-ийг ашиглахад тохиромж муутай болсон гэсэн үг юм.

Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж агаарын температур -18.6⁰С, хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур 17.8⁰С буюу сарын дунджаар жилийн агаарын температурын агууриг 36.4⁰С, сарын дундаж их бага температурын дунджаар 58.6⁰С, үнэмлэхүй их бага температураар 77.4⁰С–ийн агууригтай буюу жилийн температурын ихээхэн хэлбэлзэлтэй байгаа нь харагдана.

Газрын гадарга

Монгол орны физик газарзүйн мужлалаар Говийн их мужийн дэд муж салбар уулсын үргэлжлэл болох нам уулс, ухаа гүвээ толгодорхог, гадаргатай. Далайн түвшнээс дээш дунджаар 1200-1350 м өргөгдсөн умарт говийн бор хөрсний хойд зах, уулын хээрийн хүрэн хөрсний заагтай хиллэнэ.

Хүрэн хөрсний дэдхэвшинж болох нам уулс, ухаа гүвээ толгодын цайвар хүрэн хөрс делювийн карбонатлаг чулуулаг дээр үүссэн байна. Байгалийн бүсийн хувьд уулын хээрийн нам уулс, ухаа гүвээ толгод,тал хөндийн хуурай хээрийн бүсэд хамрагдана.

Ургамал

Монголын нэрт ургамал судлаач, академич Н.Өлзийхутаг “Монгол орны ургамлын аймгийн тойм” (1982) бүтээлдээ сумдын нутгийг монгол орны ургамал газарзүйн мужлалаар Дундад халхын хээрийн тойрогт хамруулан авч үзсэн байдаг (Өлзийхутаг, 1982).

Ургамалжлын хувьд тэгш тал газар болон жигд өргөгдсөн тэгшивтэр газруудаар ихэвчлэн Шивээт хялганат хээр зонхилон тархах зүй тогтолтой юм. Эдгээрийн дотор нэн ялангуяа Харгана-Үетэн-Хялганат (*Stipa krylovii*, *S.grandis*, *Cleistogenes squarrosa*, *Leymus chinensis*, *Agropogon cristatum*, *Poa attenuata*, *Caragana microphylla*) бүлгэмдэл зонхилох байр эзлэнэ. Үүний зэрэгцээ Харгана-Түнгэ-Хялганат (*Stipa krylovii*, *Leymus chinensis*, *Caragana microphylla*) хөнгөн хөрстэй газраар Харгана (*Caragana microphylla*) бүхий Агь-Хазаар өвс-Хялганат (*Stipa krylovii*, *Cleistogenes squarrosa*, *Artemisa frigida*) хээр нилээд өргөн тохиолдоно.

Талбай нь Дундад халхын хээр бөгөөд зүүн тийш Дорнод Монголын хээрийн тойрогт хамаарагдаг. Монголын зүүн өмнөд хэсгийн хээрт амьдралын хэлбэрийн хувьд том дэгнүүлт үетэн зонхилдгоороо онцлогтой. Мөн сүүлийн жилүүдэд хуурайшилт нэмэгдэж байгаатай холбоотойгоор харганат *Caragana*, сонгинот *Allium*, хазаар өвст *Cleistogenes*, Түнгэт *Leymus* бүлгэмдлүүдийн талбай ихээр нэмэгдсэн. Энэ нутагт хойноосоо Дундад халхын хээр, баруунаасаа Олон нууруудын хөндийн цөлөрхөг хээрийн ургамалжил нөлөөлнө. Ихэвчлэн хуурай хээрийн ургамалжил зонхилно.

Төслийн район нь ерөнхийдөө тойргийн зүүн өмнөд хэсгийг хамрах бөгөөд энэ орчмын ургамалжилт нь хээрийн ургамалжилттай бөгөөд зонхилгогч нь дэгнүүлт ургамал хялгана *Stipa*, хазаар өвст *Cleistogenes*, Түнгэт *Leymus* зонхилхоос гадна сөөг, сөөгөнцөр ургамал болох харгана *Caragana*, Давст хотгороор бударгана *Salsola*, улаан бударгана *Reamurea soongorica* зэрэг бутлаг ургамлууд зонхилон тохиолдоно.

Усан орчин

Бор-Өндөрийн хайлуур жоншны дүүрэг нь гидрогеологийн хойд системийн хэрлэн мөрний газрын доорх ай савд багтдаг. Тус бүс нутаг нь бага хэмжээний агаар мандлын хур тунадсаар тэжээгддэг, тогтмол усны урсгал үгүй, зуны аадар бороотой үед усны урсгалтай хуурай хөндий өргөн хөгжсөн байдаг. Дүүргийн гидрогеологийн нөхцөл нь түүний геологийн тогтоц, газар нутгийн тектоникийн онцлог шинж, чулуулгийн литологи, газрын доорх усны динамик, цаг уурын хуурайшилт болон бусад хүчин зүйлүүдээр тодорхойлогддог.

Судалгааны талбай байрлах дүүргийн хэмжээнд өөр өөр насны вулканоген-тунамал болон тунамал, интрузив чулуулгуудад ан цавын буюу ан цав-судлын газрын доорх ус их хөгжсөн байдаг. Хэмхдэст сэвсгэр хурдас чулуулагт нүх сүвийн-уст давхарга тааралддаг. Дүүргийн хэмжээнд дараах насны ус агуулсан хурдас чулуулгууд тархсан байдаг. Үүнд: Голоцений аллюви-пролювийн гаралтай сэвсгэр хурдасны нүх сүвийн уст давхарга, түрүү цэрдийн насны тунамал хурдасны уст бүрдэл, пермийн насны галт уулын болон триасын насны гранитоидын ан цавын уст бүрдэл, хожуу палеозойн насны интрузив чулуулгийн ан цавын уст бүрдэл.

Дөрөвдөгчийн насны аллюви-пролювийн гаралтай сэвсгэр хурдасны уст давхарга. Энэ насны хөрсний ус нь дүүргийн хэмжээнд зүүн хойд, төв болон зүүн, баруун өмнөд хэсэгт орших гүн хэрчигдсэн түр зуурын урсгал усны болон нэлээд томоохон хөндийнүүдээр тархан хөгжсөн байдаг. Ус агуулагч чулуулаг нь 0,8-2 м-ээс 12 м хүртэл зузаантай хайрга, дайрга, элс, дайргат элсэнцэр болон шавранцраас бүрэлдэн тогтоно. Хөрсний усны байрших гүн нь 1-2 м-ээс

хэтрэхгүй ба энэ ус нь дүүргийн талбайн зарим газруудад газрын гадаргууд хужиртай болон намагтай хэсгийг үүсгэсэн байдлаар илрэх бөгөөд өвлийн улиралд хөлдсөн тошин байдлаар байдаг. Худгуудын ундарга нь усны түвшин 1 м хүртэл буурвал 0,5-1,0 л/сек-ээс хэтрэхгүй. Энэ насны уст давхарга нь дүүргийн хэмжээнд хаа сайгүй тааралдах ба энэ давхаргын ус нь 0,2-0,9 г/л эрдэжилттэй цэнгэг ус бөгөөд гидрокарбонат, кальцийн, кальци-магнийн болон кальци-натрийн найрлагатай байдаг. Фторын агуулга нь 1,2-5,8 мг/л хооронд хэлбэлзэнэ.

Түүрүү цэрдийн насны тунамал хурдасны уст бүрдэл. Энэ бүрдлийн газрын доорх ус нь районы зүүн урд хэсгээр бага талбайд тархсан байх бөгөөд алевролит, элсэн чулууны үеүдтэй нэг зүгт чиглэсэн (моноклинали) гравелит болон конгломератын зузаалагт тааралдана. Судалгааны талбай байрлах районы нутаг дэвсгэрт базальттай энэ насны хурдас чулуулаг хиллэж заагласан хэсгээр гарч илэрсэн нэг булаг шанд байдаг. Энэ булаг нь даралтгүй устай ба ундарга нь 1,8 л/сек хүртэл байсан (1976 он). Эрлийн өрөмдсөн цооногуудаар (26Г-28Г) газрын доорх ус 1,3 м (28Г)-т болон 10,34 м (26Г) гүнд тус тус илэрсэн. Цооног дахь усны ундарга нь усны түвшин 47,0-19,32 м буурах үед 0,20-4,65 л/сек болдог. Ус нь 0,26-0,4 г/л эрдэжилттэй, 2,92 мг/л хүртэл фторын агуулгатай цэнгэг, устай бөгөөд гидрокарбонат натрийн болон кальци-магни-натрийн найрлагатай.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2025 оны батлагдсан БОМТ-д уурхайн дотоод үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилтийг бууруулах болзошгүй эрсдэл, хүчиллэг урсац бүхий үерийн үед ажиллах төлөвлөгөөтэй болох, хог хаягдлыг байгаль орчинд халгуйгээр зайлуулах, устгах системийг бий болгох орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх, үйл ажиллагааны явцад учирч болзошгүй эрсдэл аюулаас бүрэн сэргийлж ажиллах, энэтэй холбоотой сургалтыг тогтмол зохион байгуулах, илүү ашиглалт бүхий талбайг тодорхой хэмжээгээр чөлөөлөх

4.1. Агаарын бохирдол, тоосжилт бууруулах чиглэлээр:

1. Тоосжилтыг багасгах зорилгоор авто замуудын усалгаа арчилгааг тогтмол хийх, мөн цаг агаарын мэдээний дагуу их салхитай үед ажиллах байх, машины хорт хийг багасгах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Замын тоосжилт дарах ажил /дулааны улиралд ээлжийн туршид 1-3 удаа усалдаг бөгөөд усалгаанд уурхайн хуучин карьерт хуримтлагдсан цөөрмийн усыг ашигладаг болно.
2. *Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг ханган тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хийг үйлдвэрлэгчээс гаргасан хэм хэмжээнд байлгах:* Нийт машин механизмуудыг техникийн үзлэг оношилгоонд хамруулсан бөгөөд засвар үйлчилгээнд нь байнга анхааран ажиллаж байна.
3. *Гадаад тээврийн замын арчилгааг байнга хийж байх:* Уурхайн бүтээгдэхүүн болон бусад хүчин зүйлсээс хамаарсан гадаад тээвэрлэлт харьцангуй бага бөгөөд уурхай уруу чиглэсэн уурхайн бүсээс 200-300 м-т байрлах гадаад тээврийн замыг байнга засаж байгаа болно.
4. Гадаад тээврийн замын арчилгааг байнга хийж байх: 2025 оны хавар, зун, намрын улирлуудад гадаад тээврийн замыг байнга засаж арчилгааг хийж гүйцэтгэсэн болно.
5. *Агаарын тоосжилт буюу PM2.5, 10 хэмжигч 1 цэг байршуулах:* Агаарын орчны хяналт шинжилгээний хүрээнд 2025 оны 10-р сарын 28-нд байгаль орчны мэргэжлийн “Энвишгрийн” ХХК-ны мэргэжилтнүүд агаарын хэмжилт шинжилгээг хийж гүйцэтгэсэн болно. /Жич: Орчны шинжилгээний хөтөлбөрийн биелэлтэнд оруулав./



Зураг.5. Гадаад тээврийн зам засаж буй байдал, 2025-6, 9-р сар



Зураг.6. Гадаад тээврийн зам засаж буй байдал

4.2. Хөрсний бохирдлоос хамгаалах сэргийлэх чиглэлээр

1. Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэн, тээврийн хэрэгслийн ажиллах болон зогсоох талбайд байнга хяналт тавин ажиллаж байна. Одоогийн байдлаар асгаралт үүсээгүй боловч гэнэтийн асгаралтын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.
2. Уурхайн дотоод болон уурхайгаас гарсан замууд ч гэсэн салаа зам үүсэх байх талаар анхааран ажиллаж байна.
3. Хөрсний мониторинг хийж, дээж судалгааг хийж байна.


4. Одоо явуулж буй уурхайн карьер болон уурхайн кемпийн ойр орчимд жалга байхгүй бөгөөд үерийн усны нөлөөлөл харьцангуй бага юм. Гэвч гэнэтийн үерээс сэргийлэн карьер болон кемпын орчимд хамгаалалтын суваг татах ажлыг хийж байна.
5. Уурхайн кемп стандартын нийтийн бие засах газрыг стандартын дагуу болгон ашиглаж байна.
6. Уурхайлалтын явцад гарсан шимт хөрснийг стандартын дагуу овоолго үүсгэн хадгалж байна.



Зураг.7. Шимт хөрсний овоолгын зураг

4.3. Усан орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагаа

1. Хур бороо ус нь ихэвчлэн жалга, шуудуу болон барилгын дээвэр зэргээр дамжин урсан тогтдог. Жалга шуудуугаар урсан борооны ус нь хэсэг хугацааны дараа шууд газарт шингэн, ууршиж агаарт түгдэг. Бид эхний ээлжинд уурхайн оффис, ажилчдын байрны борооны ус хоолойн доор ус хураах сав байрлуулсан болно. Харьцангуй бороо бага ордог боловч борооны ус хуримтлуулах боломж байна. Хуримтлагдсан усыг замын усалгаанд ашиглаж байна.
2. Уурхайн ойролцоох орших 1 уст цэг буюу булаг, уурхайн дотор байгаа ашиглагддаггүй карьерт хуримтлагдсан цөөрмийн эрэг орчмоор цэвэрлэгээг 2024 оны 10-р сард хийж гүйцэтгэв.
3. 2025 оны ус ашиглах дүгнэлтийг Умард Говийн гүвээт-Халхын дундад талын савын газрын захиргаанаас 2025 онд гаргуулахаар хүсэлтээ өгөөд баталгаажих шатандаа хүлээгдэж байгаа болно.
4. Мөн сумын байгаль орчны байцаагчаас уурхайд ус ашиглагчийн дэвтрийг үүсгэн авч тоолуурын заалтыг баталгаажуулан явж байна.



ХЯНАСАГ СУМЫН БОХУУ

ТООЛУУРЫН № 24100088

2025 ОНД АШИГЛАСАН УСНЫ ЗАРЦУУЛАЛТ

№	Огноо	Тоолуурын заалт	Зөрүү	Төлбөр /төг/	Тайзвар	Бичигт хийсэн	Ашиглагчийг төлөвж байлцсан	Хянасан татварыг байлгач
1								
2								
3								
4								
5	06.06.00002							
6								
7								
8								
9								
10	10-17	0020.7	00203					
11								
12								

Нийт: _____

Танх тэмдэг: Тоолуур задарсан бол (-) Ажлааныг бөөгцүүлсэн бол (+)

ХЯНАСАГ СУМЫН БОХУУ *Ц. ДАНБАТ*

Ус ашиглагч иргэн аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагааны явцад анхаарч ажиллах зөвлөмж

- Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ
- Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно
- Ус ашиглах гэрээний биелэлтийг жил бүрийн 12-р сарын 20-ны дотор дүгнэж, тэмдэглэл үйлдсэнээр дараа жилийн ус ашиглуулах дүгнэлт гаргуулах эрхтэй болно.
- Ажилчдыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах
- Газрын доорх цэнгэг усны ашиглалтыг хязгаарлан, хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах технологи нэвтрүүлж ажиллах
- Ус ашиглагч гэрээгээр хүлээсэн үүргээ тогтоосон хугацаанд зохих шаардлагад нийцүүлэн биелүүлэх
- Ус ашиглагч ашиглалтын зориулалтыг өөрчлөх, зөвшөөрөлгүйгээр цооног ороомдох, худаг гаргах, суваг шуудуу татахыг хориглоно
- Аж ахуйн нэгж гэрээнд заагдсан хэмжээнд ус ашиглаж байгаа, усны тоолуур, ус ашигласны төлбөрийн биелэлтэд сав газрын захиргаа, БОАЖГ, сумын татварын байцаагч, Байгаль хамгаалагч нар хяналт тавьж байх
- Газрын доорх ус ашигладаг бол ус авах цэг, цооног, худаг, ус дамжуулах шугамын оролт тус бүр дээр тоолуур суурилуулах
- Гадаргын ус ашигладаг бол ус авах барилга байгууламжийн шахуурга бүр дээр эсхүл ус дамжуулах гол хоолойн эх дээр тоолуур суурилуулах
- Усны тоолуур эвдрэсэн тохиолдолд ус хангагч байгууллагад яаралтай мэдэгдэж, усны тоолуурыг шугамнаас салгах, баталгаажуулсны дараа буцааж тавихад байлцах, тоолуурын засвар, суурилуулалтыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар хийлгэх
- Ус ашиглагч нь шууд сольж тавих нөөц, баталгаатай усны тоолууртай бол сумын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч, татварын байцаагчдыг байлцуулан сольж, заалтыг хоёр тал бүртгэж акт үйлдэж баталгаажуулах
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж дууссан цооноогоо битүүмжлэн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумын Засаг даргад хүлээлгэж өгнө
- Хонгогт 50 шоо метрээс их ус ашиглагч Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.7-д заасны дагуу дотоод хяналтын цэг, техник хэрэгсэлтэй байх ба усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах
- Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах, ашиглалтын явцад гарах бохир усыг хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх, эсхүл шууд зайлуулах

ДЭВТРИЙН ДУГААР: 000000245

СУМЫН НЭР: ХЭНТИЙ ДАРХАН СУМ

ХАЯГ БАЙРШИЛ: 2-р БАГ

ТӨВЧ МЭДЭЭЛЭЛ

1	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Жин Хуа Орд ХХК
2	Тусгай зөвшөөрлийн дугаар	НВ 6701
3	Регистрийн дугаар	5002486.
4	Захирал /уурхайн дарга/-ын нэр	Б. ЧУЛУУН
5	Холбоо барих утас	88602981.
6	И-мэйл хаяг	
7	Ус ашиглах зориулалт	АХУЙН ХЭРЭГЛЭЭ
8	Ус ашиглах дүгнэлттэй эсэх	-
9	Ус ашиглах гэрээтэй эсэх /гэрээний дугаар/ Тоолуурын тоо	-
10	Тоолуурын нэр, төрөл	№1 LXSC
		№2
		№3
		№4
11	Суурилуулсан байгууллага огноо	№1
		№2
		№3
		№4
12	Баталгаажуулсан байгууллага огноо	№1
		№2
		№3
		№4

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ: _____ / _____ /

Зураг.8. Уурхайн ус ашиглагчийн дэвтэр болон баталгаажуулсан баримт

Үйлчилгээ	Төлөв сонгох	Хүсэлтийн дугаар	Огноо	
Хайх	Цэвэрлэх			
Дугаар	Үйлчилгээний нэр	Төлөв	Огноо	Үйлдэл
E-2510-000319	Ус ашиглуулах дүгнэлт	Боловсруулж байгаа	2025/10/22	Дэлгэрэнгүй >
< 1 > 10 / хуудас				

Үйлчилгээний нэр сонгон...	Төрөл сонгох	Төлөв сонгох	Хайх	Цэвэрлэх		
№	Үйлчилгээний нэр	Тайлбар	Төрөл	Төлөв	Огноо	Үйлдэл
1	Ус ашиглуулах дүгнэлт	Мэргэжилтэн Сарантуяа таны E-2510-000319 дугаартай хүсэлтийг хүлээн авлаа.	Үйлчилгээ	Уншсан	2025/10/24 16:09:48	>
< 1 > 10 / хуудас						

4.4. Амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа

1. Уурхайн нөхөн сэргээлтэнд шаардлагатай биологийн төрөл зүйлийг бүрдүүлэх үүднээс уурхайн эвдэрсэн 1 га талбайд туршилтын талбайг байгуулахаар ажиллаж байна. Энэхүү талбайд байгалийн бүсэд зохицсон ургамлыг үржүүлэх, сонгон шалгаруулах тариалалтыг явуулах болно.
2. Уурхайн ажилчдад байгаль орчны хууль, дүрэм журамтай холбоотой 1 өдрийн сургалтыг 2025 оны 10-р сард байгаль орчны үнэлгээний “Энвишнгрин” ХХК-тай хамтран зохион байгуулж тус компаний гүйцэтгэх захирал Жаргалсайхан сургалтыг удирдан явуулсан болно.
3. Уурхайн лицензийн талбайн хилээр овоолсон шороо бүхий далан, шуудуу татсан байгаа бөгөөд эдгээр нь мал, амьтдыг ил уурхай болон бусад байгууламж уруу нэвтрэхээс сэргийлж байгаа үйл ажиллагаа юм.


Сөрөг нөлөөллийг бууруулах агаар, ус, хөрс, амьтан ургамлын чиглэлээр нийт 15 ажил төлөвлөсөн бөгөөд 13-г нь хийж гүйцэтгэсэн болно.

5. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛТ

Нөхөн сэргээлтийн ажлыг хийхдээ “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн шаардлага” стандартыг баримтлан Уурхайн зүүн жигүүрийн сул орон зайд нийт 10 мянган м³ дотоод овоолгын дүүргэлт хийгээд техникийн нөхөн дүүргэлтийг 1 га талбайд эхлүүлж байгаа болно. Уурхайн олборлолтын нөхцөлтэй уялдан жил бүр нөхөн сэргээлтийг боломжгүй бөгөөд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг ажлыг дараа жилд шилжүүлэн хийх болно. Мөн нөхөн сэргээлтийн барьцаа төлбөрт нийт 37,500,000 төгрөгийг холбогдох дансанд байршуулсан болно.

Илүү ашиглалт бүхий талбайг нөхөн сэргээсэн байдал:

БОННУ-д тусгасны дагуу илүү газар ашиглалтын зөрчлөө арилган, тоног төхөөрөмжөө нүүлгэн шилжүүлж, газар ашиглалтын зөрчилгүй ажиллахаар шилжүүлж нөхөн сэргээх ажлыг эхлүүлээд явж байна.



Зураг.9. Илүү газар ашиглалтыг тодорхойлсон дроны боловсруулалтын зураг



Зураг.10. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг



Зураг.11. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,



Зураг.12. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,



Зураг.13. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,



Зураг.14. Илүү ашиглалт явуулсан газраас тоног төхөөрөмж шилжүүлж буй зураг,

Дүгнэлт: Нөхөн сэргээлтийн чиглэлээр нийт 4 ажил төлөвлөсөн бөгөөд 4-г нь хийж гүйцэтгэсэн болно.

6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ

2023 онд батлагдсан БОННУ-ны 5 жилийн БОМТ-д тусгагдсан талуудын оролцоог хангах, дүйцүүлэн хамгаалал нь нөлөөлөлд өртсөн бүс нутагт хэрэгжих гэсэн ажлыг эхлүүлэхээр сумын иргэдэд таниулах ажлыг эхлүүлэхээд байна. Энэхүү ажил нь төслийн зорилтот газар нутагт үйл ажиллагаа явуулж буй зорилтот үр шим хүртэгчдийн амьжиргааг дэмжих, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх замаар биологийн олон янз байдлыг хамгаалах, эко системийн үйлчилгээг сайжруулах, газрын доройтлыг бууруулах зорилгоор бичил төсөл сонгон шалгаруулж санхүүжүүлэх бөгөөд бичил төслийг нутгийн иргэдийн оролцоотой зэрлэг амьтны мониторинг хийх, Ховор эмийн болон бусад ашигт ургамал тарималжуулан хамгаалах, нутгийн иргэдэд түшиглэсэн зэрлэг амьтан ургамал хамгаалах санаачилгыг дэмжих зэрэг байх юм.

Дүгнэлт: Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний чиглэлээр агаар, ус, хөрс, амьтан ургамлын чиглэлээр 1 ажил төлөвлөсөн бөгөөд 1-г нь хийж гүйцэтгэсэн болно.

7. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1. Компаний ажилчдад ШУТИС-н ХШУС-н гамшгаас хамгаалах менежмент хичээлийн багш Ч.Даваасүрэн 2025 оны 10-р сарын 28-нд галын аюулгүй байдал, авах арга хэмжээний талаар сургалтыг зохион байгуулсан болно. Мөн ажилчдад галын аюулгүй байдлыг анхааруулах сурталчилгааны самбарыг байрлуулан ажиллаж байна.
2. Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж зохих стандартын дагуу ажиллаж байна.
3. Хаанхулд ХХК-ны Хаан хулд сургалтын төвөөс 2025 оны 9-р сарын 12-нд компаний нийт 40 гаруй ажилчдад Хөдөлмөр хамгааллын сургалтыг зохион байгуулж, сертификатыг олгосон байна. /хавсралт баримтыг оруулав/
4. Мөн компаний 2025 онд ажилчдыг жил бүрийн эрүүл ахуйн үзлэгт оруулсан болно. /хавсралт баримтыг оруулав/
5. Ажилчдад хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, хувцсаар байнга хангагдан ажиллаж байна.
6. Анхны тусламжийг хэрэгслийг болзошгүй бэлэн байдалд бэлтгэн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Анхны тусламжийн хэрэгслүүдийг бэлтгэсэн болно.
7. Мөн уурхайн хилийн хүрээгээр хамгаалалтын зонд овоолго үүсгэж мал, амьтан орж ирэхээс сэргийлэн ажиллаж байна.





Зураг.15. галын булан, унтраах хэрэгсэл, ослын ажиллагааны схем зураг





Зураг.16. ХАБЭА-н санамж

“Жин Хуа Орд” ХХК
(байгууллагын нэр)

MNS 4969:2000

**ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ,
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДЭВТЭР**

(Цех, хэсгийн нэр)

Эхэлсэн: 20__ оны __ сарын __ өдөр
Дууссан: 20__ оны __ сарын __ өдөр

№	Овог, нэр	Он, сар, өдөр	Мэргэжил	Зэрэг	Хийгдэх ажил	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа	Зааварчилгаа авсан хүний гарын үсэг	Зааварчилгаа өгсөн хүний гарын үсэг
1	刘保军	2023.11	维修		禁止交叉作业	刘保军	刘保军	刘保军
2	王洪程	2023.11	维修		禁止交叉作业	王洪程	王洪程	王洪程
3	王建文	2023.11	电工		穿戴电工服饰	王建文	王建文	王建文
4	靳立志	2023.11	岗位工		戴安全帽	靳立志	靳立志	靳立志
5	杨俊涛	2023.11	铲车司机		注意避让行人	杨俊涛	杨俊涛	杨俊涛
6	齐艳东	2023.11	铲车司机		注意避让行人	齐艳东	齐艳东	齐艳东
7	隋景超	2023.11	电工		穿戴电工服饰	隋景超	隋景超	隋景超
8	郝永顺	2023.11	岗位工		戴安全帽	郝永顺	郝永顺	郝永顺
9	郝永福	2023.11	岗位工		戴安全帽	郝永福	郝永福	郝永福
1	刘保军	2023.11	维修		巡查	刘保军	刘保军	刘保军
2	王洪程	2023.11	维修		巡查	王洪程	王洪程	王洪程
3	王建文	2023.11	电工		巡查	王建文	王建文	王建文
4	靳立志	2023.11	岗位工		安全生产	靳立志	靳立志	靳立志
5	杨俊涛	2023.11	铲车司机		供料	杨俊涛	杨俊涛	杨俊涛
6	齐艳东	2023.11	铲车司机		供料	齐艳东	齐艳东	齐艳东
7	隋景超	2023.11	电工		供料	隋景超	隋景超	隋景超

Зураг.17. ХАБЭА-н заавар өгсөн тэмдэглэл

Дүгнэлт: Осол, эрсдлийн менежментийн чиглэлээр нийт 7 ажил төлөвлөсөн бөгөөд 6-г нь хийж гүйцэтгэсэн болно.



8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн талбайд хийсэн агаарын дээж шинжилгээ:

Төслийн үйл ажиллагаанаас гарах тоосжилт нь уурхай болон техникийн яндангаас гарах хорт хий зэрэг нь агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн хэлбэр болно гэж тооцоолсон бөгөөд тухайн үйл ажиллагаанд хэрэглэгдэх машин техник шороон замаар явах үедээ гаргах тоосжилт нь гол сөрөг нөлөөлөл болох юм.

“Жинхуа орд” ХХК-ний Хэнтий аймгийн Дархан сумын нутагт хэрэгжиж буй “Дөрвөлжингийн төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах” төслийн ойр орчны газар нь уурхайн төвлөрсөн бүс юм.

2025 оны 10-р сарын 28-нд байгаль орчны мэргэжлийн “Энвишгрийн” ХХК-ны мэргэжилтнүүд агаарын хэмжилт шинжилгээг уурхайн газар дээр очиж байдалтай танилцан агаарт дахь тоосжилт, CO₂ болон дуу чимээний түвшинг зөөврийн багажуудын тусламжтайгаар хийж гүйцэтгэлээ. Дээрх хэмжилт судалгаанд агаарын тоосжилт хэмжигч Particle counter болон Dust track багажуудыг ашигласан болно.





Зураг 18. Агаарын хэмжилт хийсэн цэг

Агаарын тоосжилтын хэмжилтийн явцад кемпийн талбайд PM_{10} –н агууламж 3 мг/м^3 , $PM_{2.5}$ –н агууламж 2 мг/м^3 уурхайн талбайд PM_{10} –н агууламж 17 мг/м^3 , $PM_{2.5}$ –н агууламж 4 мг/м^3 утгатай гарч байв. Хэмжилтийг нийт 50 секундын хугацаанд хийсэн бөгөөд энэ нь тухайн үеийн утгыг харуулж байгаа юм. Агаарын чанарын стандарт –MNS 4585:2016-нд 24 цагийн хэмжилтийн стандарт PM_{10} 100 мг/м^3 , $PM_{2.5}$ 50 мг/м^3 гэж заасан бөгөөд эдгээр утгаас бага гарч байв.

Хэмжилтийн явцад гадаад орчны температур -2°C , агаарын чийгшил кемпийн талбайд 51.8%, Уурхайн талбайд 65.6% нийт тоосонцорын агууламж 261 мкг/м^3 байв.

Цаашид төслийн үйл ажиллагааны явцад тухайн газар орчмын агаарт тоосонцорын бохирдол үүсэх тул тэрхүү бохирдлоос хамгаалах үйл ажиллагаа, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийн дагуу иж бүрэн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Усны бохирдлын хяналт


Уурхайн ойролцоох уст цэгүүдийн судалгааны явцад дараахь цэгүүдийг тогтоосон болно.

Үүнд:

- Уурхайн ашиглахгүй байгаа карьерт 1290 м түвшнээс доош тогтсон тогтоол ус – ХӨ- $46^\circ12'46.4''$, $3\text{У}-109^\circ18'32.2''$,
- Далан түрүүний амралтын хойд хэсэгт байрлах булаг - ХӨ- $46^\circ11'46.5''$, $3\text{У}-109^\circ20'49.1''$



Зураг.19. Уст цэгүүдийн байрлалын зураг



Зураг .20. Уурхайн карьерт үүссэн хиймэл нуурын зураг



Зураг .21. Уурхайн карьерт үүссэн хиймэл нуураас дээж авч байдал



Зураг .22. Далантүрүүний булгийн уснаас лээж авч буй зураг

Судалгааны явцад дээрх уст цэгүүдээс усны дээж авч ШУА-н ГЭГЗХ-н усны лабораторит шинжлүүлсэн болно. Шинжилгээний дүнг дараахь байдлаар орууллаа.

Далантүрүүний Булгийн шинжилгээний хариу - Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натри-кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь "Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998" стандартын шаардлага хангаж байна.

Хүснэгт .1. Булгийн усны химийн шинжилгээний дүн

Анион	1дм ³ -д байгаа			Катион	1дм ³ -д байгаа		
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-кв%
Cl ⁻	25.2	0.71	12.6	Na ⁺⁺ +K ⁺	54.6	2.38	42.3
SO ₄ ⁻	55.0	1.15	20.4	Ca ⁺⁺	47.1	2.35	41.8
NO ₂ ⁻	0.0	0.00	0.0	Mg ⁺⁺	10.7	0.88	15.7
NO ₃ ⁻	10.0	0.16	2.9	NH ₄ ⁺	0.2	0.01	0.2
CO ₃ ⁻	0.0	0.00	0.0	Fe ⁺⁺	0.0	0.00	0.0
HCO ₃ ⁻	219.6	3.60	64.1	Fe ⁺⁺⁺	0.0	0.00	0.0
Дүн	309.8	5.62	100.0	Дүн	112.6	5.62	100.0

Уурхайн тогтоол усны шинжилгээний хариу - Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586:1998” стандартын шаардлага хангаж байгаа ч төмрийн ион 0.5 мг/л илэрсэн байна.

Хүснэгт.2. Гүний худгийн усны химийн шинжилгээний дүн

Анион	1дм ³ -д байгаа			Катион	1дм ³ -д байгаа		
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-кв%
Cl ⁻	3.9	0.11	2.7	Na ⁺⁺ +K ⁺	16.1	0.70	17.1
SO ₄ ⁻	20.0	0.42	10.2	Ca ⁺⁺	41.1	2.05	50.1
NO ₂ ⁻	0.01	0.00	0.0	Mg ⁺⁺	15.3	1.26	30.8
NO ₃ ⁻	4.0	0.06	1.6	NH ₄ ⁺	1.5	0.08	2.0
CO ₃ ⁻	0.0	0.00	0.0	Fe ⁺⁺	0.0	0.00	0.0
HCO ₃ ⁻	213.5	3.50	85.5	Fe ⁺⁺⁺	0.0	0.00	0.0
Дүн	241.4	4.09	100.0	Дүн	74.0	4.09	100.0

Дээрх шинжилгээний хариунаас үзвэл Далантүрүүний Булгийн ус ундны усны шаардлагыг хангаж байна. Харин уурхайн карьерт дахь тогтоол уснаас төмрийн агууламж илэрсэн нь орд газрын төмрийн хүдрийн агууламж өндөртэй холбоотой юм. Дээрх цаашид хүчиллэг урсац үүсэхээс сэргийлэн ажиллах нь зүйтэй юм.

Төслийн талбайн хөрсний судалгаа өнөөгийн байдал

Хөрсний судалгаанд google-ийн зургийн суурийг ашиглан 1:8000-ны масштабын нарийвчлалаар судалгаа явуулж үндсэн зүсэлт хийж хөрсний хүнд элементийн 3 ш шинжилгээ

хийлгэхээр “Инженер геодези” компаний хөрсний лабораторид өгч дараах шинжилгээг хийлгэв.



Зураг 23. Хөрсний дээж авч байна.

Лабораторийн шинжилгээний дүнгээс үзэхэд 1-р зүсэлтийн ялзмаг агуулалт дээд үедээ 0,35-0,36 %, хөрсний орчин РН-8,22-8,80 буюу сулавтар шүлтлэг, 100 г хөрсөндэх шингээгдсэн сууриудын нийлбэр (Са+Mg) 16,0-11,0 мг/экв байгаагийн дийлэнх хувийг кальцийн катион давамгайлна. 100 г хөрсөн дэх хөдөлгөөнт фосфор 2,0-1,2 мг, солилцох кали 14,0-16,0 мг байна. Шинжилгээний дүнгээс үзвэл эвдрэлд орсон газрын хөрсний шим тэжээлийн бодисын агууламж солилцох кали дунд зэрэг хангамжтай, азот, фосфороор дундаас доош хангамжтай байна. (хүснэгт № 17, зүсэлт № 1).

Хөрсний цахилгаан дамжуулах шинж чанараас үзвэл хүн-амьтанд нөлөөлөх хортой давсгүй байна.

Хөрсний механикийн бүрэлдэхүүн бүх үе давхрагадаа элсэнцэр байгаагийн дийлэнх хувийг 0,25-0,05 мм диаметртай жижиг хэсгүүд давамгайлна. (хүснэгт №18) Хөрсний хүнд металлын шинжилгээг холимог дээжинд хийж үзэхэд хүн-амьтанд хор хөнөөлгүй байна. (хүснэгт 3)

Хүснэгт 3. Кемпийн дэргэд хөрсний хүнд элементийн шинжилгээний дүн (мг/кг)

№	Лаб №	Дээжний нэр	Гүн см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb //Хар тугалга	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	23/6154	Хөрс-1	0-10	16.5	0.01	48.4	25.6	65.6	17.4
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/				150,0	3,0	100,0	100,0	300,0	150,0
Хортой агууламж /MNS 5850:2019/				1000,0	10,0	500,0	500,0	600,0	400,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/				1800,0	20,0	1200,0	1000,0	100,0	1500,0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS5850:2019/					

Хүснэгт 4. Уурхайн карьерын хөрсний хүнд элементийн шинжилгээний дүн (мг/кг)

№	Лаб №	Дээжний нэр	Гүн см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb //Хар тугалга	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	23/6154	Хөрс-2	0-10	10.5	0.01	47.5	47.1	50.8	15.5

Хүлцэх агууламж /MNS 5850:2019/	150,0	3,0	100,0	100,0	300,0	150,0
Хортой агууламж /MNS 5850:2019/	1000,0	10,0	500,0	500,0	600,0	400,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/	1800,0	20,0	1200,0	1000,0	100,0	1500,0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт	/MNS5850:2019/					

Хүснэгт 5. Эрүүл талбайн хөрсний хүнд элементийн шинжилгээний дүн (мг/кг)

№	Лаб №	Дээжний нэр	Гүн см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb //Хар тугалга	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	23/6155	Хөрс-3	0-10	6.56	ND	26.9	8.77	49.7	14.9
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/				150,0	3,0	100,0	100,0	300,0	150,0
Хортой агууламж /MNS 5850:2019/				1000,0	10,0	500,0	500,0	600,0	400,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/				1800,0	20,0	1200,0	1000,0	100,0	1500,0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS5850:2019/					


Хөрсний хүнд металлын холимог дээжийг эрүүл газраас 10 см-ийн гүнээс авлаа.




Зураг 24. Холимог дээж

Дүгнэлт: Агаарын шинжилгээг 2 цэгээс 4 удаа хийхээр төлөвлөсөн. Шинжилгээ хийгдээгүй Хөрсний шинжилгээг 3 цэгээс 4 удаа хийхээр төлөвлөсөн. 2 цэгээс 1 удаа дээж авч шинжилсэн. Усны шинжилгээг 2 цэгээс 4 удаа хийхээр төлөвлөсөн. 2 цэгээс 1 удаа дээж авч шинжилсэн.

Хэнтий амгийн Дархан сумын нутаг дахь Дөрвөлжин төмрийн уурхайн хөрсний зураг



Зураг 25. Хөрсний ангилалын зураг



Зураг 26. Хөрсний дээж авсан цэгийн байрлал


9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

1. Уурхайн талбайд аюултай хог хаягдал одоогийн байдлаар үүсгээгүй байгаа юм. Гэсэн ч аюултай хог хаягдал үүсгэж болзошгүй хүнд машин механизмыг бүртгэлжүүлэн ажиллаж байна. Хүнд машины үйлчилгээг хотод байрлах засварын газар хийлгэдэг тул уурхайн талбайд аюултай хог хаягдал үүсэхгүй.
2. Үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар, мөн дахин боловсруулах хог хаягдлыг 4-5 төрлөөр тусад нь цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, боловсруулагдахгүй хог хаягдлыг зохих журмын дагуу хаях арга хэмжээ авч ажиллаа.
3. Уурхайн хэмжээнд хог хаягдлын менежментийн боловсруулан уурхайн БОХЭ-н зөвлөх инженер хяналт тавин ажиллаж байна.

Хатуу хог хаягдлын төрөл

1. Ажлын байрууд, ажиллагсдын цайны газрын хог хаягдал
2. Төмрийн хаягдал
3. Ажлын байрууд, ажиллагсдын цайны газраас гарч буй ахуйн хог хаягдлын хэмжээ сард дунджаар 2838 кг. Ахуйн хог хаягдлыг зориулалтын хогийн бункерт хурааж, 7 хоногт 1 удаа өөрийн унаагаар ачиж зайлуулан сумын төвлөрсөн хогийн цэгт хаядаг. Механик засварын хэсэг болон үйлдвэрийн үүсэлтэй металл хаягдлыг тусгай талбайд цуглуулж, тээвэрлэн борлуулдаг ба бүрэн цэвэрлэж зайлуулсан. Хатуу хог хаягдлыг тээвэрлэх зардлыг үйл ажиллагааны зардалд тусган зарцуулдаг. Мөн сумын хот тохижуулах хэсэгтэй 1 жилийн хугацаатай гэрээ хийн хамтран ажиллаж байна. /хавсралтаар оруулав./

Ахуйн хог хаягдал:



Ахуйн хог хаягдын хадгалалт, тээвэрлэлтийн схем

1. “Хог хаягдал цуглуулах эрх бүхий байгууллага” хог хаягдал цуглуулах, тээвэрлэх зөвшөөрөлтэй, мэргэжлийн болон сумын хот тохижуулахтай хамтран ажиллаж байна.
2. “Бусад хог хаягдал” гэж аливаа хогноос дахин ашиглах боломжтой хог хаягдлын хэсгийг зайлуулахад үлдсэн ахуйн хон хаягдлыг хэсгийг хэлнэ. “Бусад хог хаягдал” -д аюултай хог хаягдал, барилгын хог хаягдал, цахилгаан барааны хаягдал ба эмнэлгийн хог хаягдал орохгүй болно.
